



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 363

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж,
данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам"-ын 6.2.1, 6.2.5, 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баянгол дүүргийн Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2012 оны 02-07-92-1276 дугаар, 2017 оны 07/103/99 дүгээр дүгнэлтээр цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 161,200,800.00 (нэг зуун жаран нэгэн сая хоёр зуун мянга найман зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Баянгол дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Н.Энхтуяад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах, газрыг нөхөн сэргээх;


2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002123

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 7 дугаар сарын 20 ны өдрийн
 363 дугаар тогтоолын хавсралт



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН БАЛАНСАД БҮРТГЭЛТЭЙ АКТАЛЖ,
 ДАНСНААС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Талбай	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Албан конторын 2 давхар барилга	1954	м.кв	1076	161,200,800.00	161,200,800.00	-
НИЙТ					(нэг зуун жаран нэгэн сая хоёр зуун мянга найман зуун)	(нэг зуун жаран нэгэн сая хоёр зуун мянга найман зуун)	-